



СОЁМБО МЭДЭЭ

“СОЁМБО” РЕДАКЦААС ЭРХЛЭН ГАРГАДАГ ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.04.01 №21 (21)

ЗАСГИЙН ГАЗАР

БҮХ НИЙТИЙН БЭЛЭН БАЙДЛЫН ЗЭРЭГТ ШИЛЖҮҮЛЭХГҮЙ

Засгийн газрын өчигдрийн хуралдаанаар улаан түвшин буюу бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэхгүй байхаар шийдвэрлэлээ.

Гэхдээ дөрөвдүгээр сарын 3-18-нд улсын хэмжээнд зарим салбарын үйл ажиллагааг хязгаарлах Улсын онцгой комиссын саналыг дэмжив. Энэ нь цар тахлын үед эрүүл мэндээ хамгаалахын зэрэгцээ эдийн засгаа сэргээх зорилгоор халдвар хамгааллын дэглэмийг мөрдөж, иргэд, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлэх бодлоготой холбоотой юм.

Дээрх хугацаанд:

- Ресторан, лоунж, саун, бассейн, алжаал тайлах төв, кино театр, үзвэр үйлчилгээ, бялдаржуулах төв, амралт сувилал, сургалтын төв ажиллахгүй
- Хоол үйлдвэрлэл, зоогийн газрууд хүргэлтээр үйлчлэх
- Усчин, гоо сайхны газрууд амралтын өдрүүдэд ажиллахгүй, бусад өдөр халдвар хамгааллын дэглэм сахиж ажиллах
- Худалдаа, үйлчилгээний газрууд хүн хоорондын зай бариулах, ариутгал, халдваргүйжүүлэлтийг дээд зэргээр хийх, нийт талбайнхаа 30 хувиас хэтрэхгүй байхаар тооцон үйлчлэх /Супермаркетууд түрдэг тэрэгний тоогоор зохицуулалт хийх/
- Нарантуул, Хархорин, Барс, Хүчит шонхор, Нарантуул-2 зэрэг томоохон зах 30 хувиар ажиллах /Амралтын өдрүүдэд ажиллахгүй/
- Дэлгүүр, худалдааны төвүүд 20 цагт хаах
- Аймаг, орон нутаг руу зорчих иргэдийн хөдөлгөөнийг хүндэтгэх шалтгаанаас бусад тохиолдолд хориглох
- Орон нутаг руу хүнс, ачаа тээвэр, малын өвс тэжээл, шатахуун тээвэрээс бусад тохиолдолд автомашины хөдөлгөөнийг хязгаарлахаар боллоо.

Тодорхой зохицуулалт хийх



зорилгоор:

- Нэг дор таваас дээш хүн цуглахгүй байх зохион байгуулалтыг төрийн болон хувийн хэвшлийн бүх шатанд хэрэгжүүлэх
- 60-аас дээш настай ахмадуудыг шаардлагагүй тохиолдолд гэрээс гарахгүй байхыг сануулах, халдвар авахаас сэргийлэх, дархлаажуулах
- Хөрсийн холбоо, иргэдийн сайн дурын ажлыг идэвхжүүлэх
- Төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, нийт ажилтан, албан хаагчдынхаа 30-аас ихгүй хувийг ажиллуулах
- Барилга, бүтээн байгуулалтад ажиллаж байгаа хүмүүс нэг дор таваас дээш бөөгнөрөхгүй байх, хүн

хоорондын зайгаа баримтлах
•Хорио цээрийн дэглэмийн хэрэгжилтийг сахиулах ажлын хэсэг байгуулах

Тандалт судалгаа, дархлаажуулалтыг эрчимжүүлэх хүрээнд:

- Ойрын хавьтлыг олж тогтоох тандалт судалгааг эрчимжүүлэх
- Гэрээр долоо хоног тусгаарлагдах иргэдэд гарын авлага, эмчилгээний багц /эм, халууны шил, витамин, гар ариутгагч зэрэг/ хүргэх
- Гадаадаас ирэх иргэдийн тусгаарлалтыг долоо хоног болгох, ингэхдээ 3, 5 дахь өдөр нь ПСР-ын шинжилгээ авч сөрөг гарсан тохиолдолд гаргах, гэрээр ажиглахыг болих

•Тусгаарлах байранд эмчлүүлж, эдгэрч гарсан иргэдийг долоо хоног гэрээр ажиглахыг цуцлах

•Орон гэргүй, асрамж шаардлагатай болон хорих ангид хүмүүжигч, түр саатуулах байранд саатуулагдсан иргэдийг дархлаажуулалтад хамруулах

•Тавдугаар сарын 1-ний өдрөөс өмнө нийслэлийн нэг сая иргэнийг дархлаажуулах

•Дөрөвдүгээр сарын 5-ны өдрөөс орон нутгийн зорилтот бүлэг /эмч, эмнэлгийн ажилтан, цагдаа, онцгой, хил гаалийн ажилтан, албан хаагчид/-ийг дархлаажуулах

•Долдугаар сарын нэгэн гэхэд орон нутгийн иргэдийг дархлаажуулж дуусгахаар төлөвлөж байна.

ХИЛИЙН ЧАНАДААС

ЭНХИЙГ САХИУЛАГЧИД ҮҮРГЭЭ НЭР ТӨРТЭЙ ГҮЙЦЭТГЭЖ БАЙНА



ИБНАУ-д явагдаж буй “Шийдвэртэй дэмжлэг” ажиллагаанд ХБНГУ-тай хамтран үүрэг гүйцэтгэж байгаа Монгол Улсын XIII ээлжийн цэргийн багийн бие бүрэлдэхүүн 3 дугаар сард хийж гүйцэтгэсэн ажлаа тайлагнаж, Цэргийн тангаргаа давтлаа.

Мөн тухайн сард үүрэг гүйцэтгэлт, сурлага, сахилга, зохион байгуулалтаараа хамт олноо тэргүүлэн ажилласан тэргүүний тасаг, офицер, ахлагч нарыг шагнаж урамшуулсан юм.

Гуравдугаар сарын тэргүүний тасагаар ахлах ахлагч Ш.Жамсран захирагчтай тасаг, тэргүүний офицероор цэргийн багийн эмч, ахлах дэслэгч Г.Маналжав, тэргүүний ахлагчаар жолооч-буудагч, ахлагч А.Гантогтох нар шалгарлаа. Шагналыг багийн захирагч, дэд хурандаа Э.Амартүвшин гардуулж, энхийг сахиулах эрхэм үйлсдээ өндөр амжилт гаргахыг хүсэн ерөөсөн юм.

Ахлах дэслэгч П.ОТГОНБААТАР

ҮЙЛ ЯВДАЛ

БҮХ ШАТНЫ ОФИЦЕР, АХЛАГЧДЫН МЭРГЭЖЛИЙН БЭЛТГЭЛИЙН ТҮВШИНГ ТОГТООНО



Зэвсэгт хүчний 326 дугаар ангид гарсан хэрэгтэй холбогдуулан ЗХЖШ-аас өчигдөр хэвлэлийн бага хурал зохион байгууллаа.

Хэвлэлийн бага хуралд ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газрын дарга, бригадын генерал С.Дашзэвэг, Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлагч, бригадын генерал Б.Амгаланбаатар, Зэвсэгт хүчний Хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын даргын орлогч, хэлтсийн дарга, хурандаа Д.Ариунболд нар оролцлоо. Тодруулбал, 2021 оны 3 дугаар сарын 28-нд Зэвсэгт хүчний 326 дугаар ангийн салааны захирагч дэслэгч Г харуулын даргын үүрэг гүйцэтгэж байх үедээ байлдагч Б-гийн биед халдаж, цэргийн дүрмийн бус харилцааны зөрчил гарган, хүнд гэмтэл учруулсан.

ЗХЖШ, Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалаас тухайн өдөр яаралтай арга хэмжээ авч, байлдагч Б-гийн тусгай хамгаалалтын нэгдсэн эмнэлэгт хүргүүлэн эмнэлгийн яаралтай тусламж үзүүлсэн боловч 3 дугаар сарын 30-нд харамсалтайгаар амь насаа алдсан юм.

Иймд талийгаачийн аав ээж, ах

дүү, төрөл төрөгсдөд БХЯ, ЗХЖШ-ын удирдлага болон Зэвсэгт хүчний нийт бие бүрэлдэхүүнийхээ өмнөөс гүн эмгэнэл илэрхийлж, уучлалт хүслээ. Гарсан хэрэг зөрчилтэй холбогдуулан БХЯ, ЗХЖШ-аас албаны хяналт шалгалт явуулж, хэрэг гарсан шалтгаан нөхцөлийг тогтоохоор ажиллаж байгаагаа энэ үеэр мэдээлсэн. Түүнчлэн Батлан хамгаалах яам, ЗХЖШ-ын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, сахилга дэг журам бэхжүүлэх салбар зөвлөлүүд яаралтай хуралдаж, холбогдох шийдвэрийг гаргаад байна. Үүнд, Зэвсэгт хүчний 326 дугаар ангийн захирагчаар ажиллаж байсан хурандаа С.Батболдыг үүрэгт ажлаас нь чөлөөлсөн юм. Цаашид цар тахлын нөхцөл байдалтай уялдуулж Зэвсэгт хүчинд алба хааж буй бүх шатны офицер, ахлагч нарын албаны төлөвшил, мэргэжлийн бэлтгэлийн түвшинг яаралтай тогтоох, шалгалтын дүнг үндэслэн цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлж, хугацаат цэргийн алба хаагчдын алба хааж буй нөхцөл байдал, цэргийн албаны талаар хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран эцэг эх, ар гэрийнхэнд нь танилцуулах юм.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР	
ӨДӨР	ШӨНӨ
+3	-8
ӨМНӨД СУДАН	
ӨДӨР	ШӨНӨ
+34	+23
АФГАНИСТАН	
ӨДӨР	ШӨНӨ
+14	+1

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,848.00	2,851.00
EUR	3,345.00	3,360.00
CNY	431.70	434.70
RUB	37.20	38.00
JPY	25.75	25.90
KRW	1.62	1.75

КОВИД-19 МЭДЭЭ

ШИНЭЭР БҮРТГЭГДСЭН	377
НИЙТ БҮРТГЭГДСЭН	8447
ЭДГЭРСЭН	4970
НАС БАРСАН	12

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

ШИНЭЭР НЭМЭГДСЭН	12
ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БҮЙ	246
ЭДГЭРСЭН	1177
НИЙТ БАТЛАГДСАН	1425

ӨРНИЙН ЗУРХАЙ

БИЛГИЙН ТООЛЛЫН 19
2021.04.01. /ПҮРЭВ ГАРАГ/
ХАВРЫН ДУНД ЦАГААЧИН ТУУЛАЙ САРЫН ДОЛООН УЛААН ШАРАГЧИН ТУУЛАЙ ӨДӨР

Үс засуулбал: Сайн нөхөртэй нөхөрлөнө.
Наран ургах, шингэх: 06.31-19.22
Барилдлага: Үл тохирох
Шүтэн барилдлага: Өтлөх үхэхүй
Суудал: Огторгуй.

Аргын тооллын 4 дүгээр сарын 1. Бархасвадь гараг. Билгийн тооллын 19, Онгоц одтой, шарагчин туулай өдөр. Өдрийн наран 6 цаг 31 минутад мандан, 19 цаг 22 минутад жаргана. Тухайн өдөр гахай житнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж биеэ энхрийлүүштэй. Эл өдөр хууль цааз гаргах, батлах, хэрэглэх, хулгай дээрмийг номхотгох, гэмтнийг шийтгэх, мал адгуус номхруулах, гарагийг тахиx, мал аж ахуйн үйл, удирдлагын суудалд суух, огторгуйн үүдийг боох, их хүмүүнтэй уулзахад сайн.

Газар хагалах, ус булгийн эх малтах, улаа гаргах, хиншүү хярвас гаргах, балгадын суурь тавих, нохой худалдан авахад муу. Өдрийн сайн цаг хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой.

Хол газар яваар одогсод зүүн хойш мөрөө гаргавал зохистой.

Үс шинээр үргээлгэх буюу засуулбал "сайн нөхөртэй учрах" хэмээн заажээ.

ЦАХИМ ШУУДАНД

"ЖУБА" СЕКТОРЫН КОМАНДЛАГЧ, ХУРАНДАА Б.ЭРДЭНЭБАТ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭЛТИЙН ТАЛААР ТАНИЛЦУУЛГА ХИЙВ



БНӨСУ-д явагдаж байгаа НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааны "Жуба" секторын цэргийн багууд цагийн байдал хүндэрсэн үед Жуба хотод байрлах НҮБ-ын онц чухал объектууд болон хамтран ажилладаг хүмүүнлэгийн бусад байгууллагуудын аюулгүй байдлыг хангаж, ажиллагсдыг нь татан гаргах,

хамгаалалтыг зохион байгуулах үүрэгтэй. Тэрхүү үүрэгтэй холбогдуулан ажиллагааны Хүчний командлагчийн орлогч дарга, Бангладеш Улсын хошууч генерал Мед Майн Улла Човдхуйруд өнгөрсөн долоо хоногт Жуба хотод ажиллалаа. Энэ үеэр "Жуба" секторын командлагч,

хурандаа Б.Эрдэнэбат тэргүүтэй секторын удирдлагууд бэлэн байдлын төлөвлөгөөг хэрхэн хэрэгжүүлэн ажиллаж байгаа талаарх танилцуулга, мэдээлэл өгсөн юм. Мөн секторын сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу БНХАУ-ын батальоны ажиллагааны бэлэн байдлын шалгалтыг штабын даргаар

ахлуулсан томилгоот бүрэлдэхүүн 3 дугаар сарын 25, 26-ны өдрүүдэд амжилттай зохион байгууллаа. Шалгалтын төгсгөлд секторын командлагч, хурандаа Б.Эрдэнэбат үүрэг гүйцэтгэлт, бэлэн байдлын талаар тодорхой үүрэг чиглэлүүдийг өгсөн юм.

Хошууч Н.ГАНТУЛГА


ТОВЧХОН

- ❖ Ажлын байрыг дэмжих хүрээнд гуравдугаар сарын 29-ний байдлаар 343 аж ахуйн нэгж, 2088 иргэнд 152.8 тэрбум төгрөгийн зээл олгоод байна. Иргэдийн авсан зээлийн дундаж хэмжээ 38 сая, аж ахуйн нэгжийнх 210 сая төгрөг байгаа юм.
- ❖ Урт хугацаат репо санхүүжилттэй зээлийг 1078 аж ахуйн нэгж, 280 иргэн /185.5 тэрбум төгрөг/ зээл авсан. Иргэдийн авсан зээлийн дундаж хэмжээ 123 сая, аж ахуйн нэгжийнх 140 сая төгрөг байгаа юм.
- ❖ 2043 зээлдэгчид 153.8 тэрбум төгрөгийн ипотекийн зээлийг олгосон. Зээлийн дундаж хэмжээ 75 сая, үүнээс Улаанбаатар хотод 83 сая, орон нутагт 55 сая төгрөг байна.
- ❖ Гуравдугаар сарын 30-ны байдлаар 290 мянган хүнийг дархлаажуулаад байна.
- ❖ Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгасан таван бодлого, 20 зорилт, 127 арга хэмжээний биелэлт 2020 оны эцсийн байдлаар 75.9 хувьтай байна.

Эх сурвалж: Засаг.мн

ТАНЫ СОНОРТ

ЦАР ТАХЛЫН ТУРАВ ДАХЬ ДАВЛАГАА ЭХНИЙ ХОЁРООСОО Ч АЮУЛТАЙ



Европын зарим улс оронд коронавирусийн халдварын нөхцөл байдал хүндрээд байна.


Германд гэхэд сүүлийн хоёр хоног дараалж халдварын батлагдсан тохиолдлын тоо хоногт 20 мянгаар нэмэгджээ. Роберт Кохийн хүрээлэнгээс халдварын тархалтыг тогтоон барьж дийлэхгүй бол хоногт халдвар авч байгаа хүний тоо удахгүй 100 мянгад хүрэхийг анхааруулсан байна. Мөн халдвар авсан хүмүүсийн дийлэнхийнх нь өвчин хүндэрч эмнэлгүүд ачааллаа дийлэхгүй, нас баралт нэмэгдэхэд аль аль талдаа бэлэн байхыг сануулсан бөгөөд эрх баригчид халдварын тархалтыг тогтоон барихын тулд бүхий л арга хэмжээг авч байгаа аж.

Улс орнууд Франц, Австри, Дани, Чех зэрэг орноос зорчиж байгаа иргэдээс коронавирусийн шинжилгээний хариутай ирэхийг шаардах болжээ. Мөн жуулчдыг 10 хоногийн хугацаатай ажиглан, тусгаарлалтад албадан оруулах гэнэ. Польшид хоногт шинээр бүртгэгдсэн халдварын тохиолдлын тоо 35 мянга давсан нь цар тахал эхэлснээс хойш 24 цагийн хугацаанд батлагдсан хамгийн өндөр үзүүлэлт болжээ. Тус улсын эрх баригчид үүнтэй холбоотойгоор хорио цээрийн нэмэлт арга хэмжээ авахаа зарлаад байгаа юм.

ОХУ АМЬТДАД ЗОРИУЛСАН КОРОНАВИРУСЫН ВАКЦИНЫГ БҮРТГЭЖЭЭ

Амьтдад зориулсан коронавирусийн вакциныг бүртгэсэн болохыг ОХУ-ын Мал эмнэлэг, ургамал хорио цээрийн улсын албаны орлогч дарга Константин Савенков сэтгүүлчдэд мэдээлэв.

Түүний хэлснээр, энэ нь одоогийн байдлаар амьтдад зориулсан дэлхийн анхны коронавирусийн вакцин юм. Уг вакциныг Россельхознадзорын "Малын эрүүл мэндийг хамгаалах төв"-д гарган авчээ.



"Карнивак-Ков" нэртэй уг вакцины эмнэлзүйн туршилтуудыг өнгөрсөн оны 10 дугаар сараас эхлүүлсэн бөгөөд нохой, муур, цагаан үнэг, усны булга, үнэг зэрэг амьтан дээр туршжээ. Судалгааны үр дүнд вакцин хийлгэсэн бүх амьтанд 100 хувь коронавирусийн эсрэг биет үүссэн байна.

Россельхознадзорын эрдэмтэд вакцин хийснээс хойш дархлаа хэр удаан тогтдогийг үргэлжлүүлэн судалж байна. Савенковын хэлснээр, одоогийн байдлаар энэ үзүүлэлт дор хаяж зургаан сар байгаа аж.

Эх сурвалж: RIA Novosti

Зөвлөгөө

Коронавируст халдвар (COVID-19) гэж юу вэ?

Амьтнаас хүнд халдварласан 7 дахь төрлийн шинэ коронавирусуур үүсгэгдсэн амьсгалын замын халдварт өвчин.

Халдвар хэрхэн дамждаг вэ?

- Халдвартай хүн ханиах, найтаах үед агаар дуслын замаар
- Бохир гар, эд зүйлсээр дамжих замаар

Ямар шинж тэмдэг илрэх вэ?

- Халуурах – 88%
- Хуурай ханиалгах – 68%
- Ядарч сульдах – 38%
- Цэр гарах – 33%
- Амьсгал давчдах – 19%
- Булчин өвдөх – 15%
- Хоолой өвдөх – 14%
- Толгой өвдөх – 14%
- Бөөлжих-5%
- Хамар битүүрэх-5%
- Гүйлгэх-4%

Нус гоожих нь өвчний шинж тэмдэг биш гэж үзэж байна.

Хэн илүү өвчилж байна вэ?

Бүх насны хүн өвчилж байна. Өндөр настан, архаг хууч өвчтэй ялангуяа зүрх судас, чихрийн шижин, артерийн даралт ихэсдэг хүмүүс хүндрэх тохиолдол их байна.

Коронавируст халдвар хаанаас үүсэлтэй вэ?

n-CoV нь сарьсан багваахайн коронавирустэй 96%, панголины коронавирустэй 86-92% ижил байгааг тогтоожээ.

Эпидеми (дэгдэлт) гэж юу вэ?

Халдварт өвчин тухайн улс оронд голомтолж, хүн амын дунд өргөн хүрээгээр тархахыг хэлнэ.

Пандеми (цар тахал) гэж юу вэ?

Халдварт өвчин дэлхийн ихэнх улс оронд олон хүнийг хамран өргөн хүрээгээр тархахыг хэлнэ.

Халдвараас хэрхэн сэргийлэх вэ?

- Халуун бүлээн шингэн ойр ойрхон уух, тагтай аяга хэрэглэх
- Давс, нимбэг, содтой бүлээн усаар ам, хоолойг зайлах
- Аяга халбагаа халуун усаар сайтар угаах
- Гараа савандаж угаах
- Нүд, ам, хамартаа гар хүрэхгүй байх
- Амны хаалт зүүх
- Ханиаж, найтааж байгаа хүнээс хол байх
- Гадуур явахдаа бээлий өмсөх
- Олон хүн цугларсан газраар явахгүй байх
- Бусадтай гар барих, үнсэхээс зайлсхийх
- Сайн унтаж амрах
- Тайван стрессгүй байх
- Аль болох бэлэн мөнгөтэй харьцахгүй байх
- 1-5 давхарт цахилгаан шат ашиглахгүй байх
- Шүлсээ хаяхгүй байх

Ахмад настан, архаг хууч өвчтэй хүмүүс юу анхаарах вэ?

Коронавируст халдвараар ахмад настан, зүрх судас, чихрийн шижин, артерийн даралт ихдэлт, хавдар, бөөр, амьсгалын замын өвчтэй, дархлаа дарангуйлах эм хэрэглэдэг хүмүүс хүндрэх эрсдэлтэйг ДЭМБ анхааруулж байна. **Иймд:**

- Эмчийн хяналтад тогтмол байх
- Эмийг эмчийн зааврын дагуу хэрэглэх
- Холбоо барих хүний утасны дугаартай байх
- Давс, чихэр, өөх тос багатай хоол хүнс хэрэглэх
- Халуун бүлээн шингэн ойр ойрхон уух
- Сайн унтаж амрах
- Тайван стрессгүй, ядрахгүй байх
- Дулаан хувцаслах, даарахгүй байх
- Хөнгөн дасгал хөдөлгөөн хийх
- Ханиаж найтааж байгаа хүнээс хол байх
- Олон нийтийн газраар явахгүй байх
- Амны хаалт зүүх
- Гараа сайтар савандаж угаах
- Бие тавгүрхвэл Яаралтай тусламжийн төв 103, СЭМҮТ 1800-2000 утсаар зөвлөгөө авах, харьяа сум, өрхийн эрүүл мэндийн төвд хандах

Аж ахуйн нэгж, байгууллага юуг анхаарах вэ?

- Албан хаагчдын биеийн халууныг өглөө бүр үзэж, өвчний шинж тэмдэг илэрвэл гэрт нь буцаах
- Үйлчилгээг цахимжуулан хүний бөөгнөрөл үүсгэхгүй байх
- Санал хүсэлт, өргөдлийг утсаар болон цахимаар авах
- Хурал уулзалтыг богино цагаар цөөн хүнтэй хийх
- Хурлын үеэр өрөөнд цэвэр агаар оруулах
- Хурлын дараа шал, ширээ, сандал зэрэг хатуу гадаргууг сайтар цэвэрлэх
- Спиртэн суурьтай гар халдваргүйжүүлэгч байлгах
- Микрофоныг спиртэн суурьтай уусмалаар арчих эсвэл нэг удаагийн уут хэрэглэх

- Цахилгаан шатны товчлуур, явган болон урсдаг шат, хаалганы бариул, компьютер, утас зэргийг өдөрт 2-оос доошгүй удаа арчиж цэвэрлэх
- Халуун аарц, чацаргана, зөгийн балтай ус, цай ажилчдадаа өгөх
- Хоолны газар ажилчдыг цөөн тоогоор ээлжлэн үйлчлэх
- Ажлын байрны дарамт, стресс үүсгэхгүй байх
- Ажилчид болон тэдний гэр бүлийн гишүүдийг амны хаалтаар хангахад дэмжлэг үзүүлэх
- Ариун цэврийн өрөөнд саван, халдваргүйжүүлэгч, гарын цаас байлгах
- Ариун цэврийн өрөөнд чийгтэй цэвэрлэгээ өдөрт 4-өөс доошгүй удаа хийх
- Урьдчилан сэргийлэх зөвлөмжийг албан тасалгаанд ил тод байрлуулах

Коронавируст халдварын эмчилгээ

Коронавируст халдварын үед шинж тэмдгийн болон вирусийн эсрэг эм, өргөн хүрээний антибиотик эмчилгээ хийж байна. Олон орны эрдэмтэн судлаачид уг өвчний эсрэг вакцин болон шинэ эм гарган авахаар туршилт судалгааг үргэжлүүлэн хийж байна.

Эх сурвалж: ЗРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ

ЭСЭРГҮҮЦЛЭЭС ҮҮСЭН ИНЭЭДМИЙН ӨДӨР

Өнөөдөр дөрөвдүгээр сарын нэгэн. Олон улсын инээдмийн баярын өдөр.

Энэ баярыг дэлхийн олон улс оронд тэмдэглэн өнгөрүүлдэг. Үүсэл гарлын тухайд авч үзвэл, Григориин он тооллын дараахнаас туйлдаж ядарч зовсон ард түмнийг хөгжөөх зорилгоор Инээдмийн баярыг тэмдэглэж ирсэн гэдэг. Европын орнуудад 17 дугаар зууны үед үүссэн гэх нь ч бий. Францын хаан энэ өдөр болдог шинэ жилийн баярыг нэгдүгээр сарын нэгэнд тэмдэглэж байхыг зарлигдсан. Үүнийг нь эсэргүүцэгчид дөрөвдүгээр сарын нэгэнд тэмдэглэлт баяраа хийсээр байж. Нэгэнт эрх баригчид он тоолол солигддог баярыг тэмдэглэхийг болиулсан тул зарим хүн тоглоом тохуу болгон нэгнээ хуурч байснаас үүссэн гэдэг нь хамгийн дөхөм.

Ямартай ч инээдмийн баярыг хаанаас хэн санаачилсан, хэрхэн үүссэнийг бүгд мэдэхгүй ч улс орон бүр тэмдэглэн өнгөрүүлж байна. Бүх нийтээрээ, нийгмээрээ ч молиго үмхэх энүүхэнд. Америкийн "Sun" сонин судлаач Жон Фредрих Хершиль дуран авиа бүтээж, саран дээрх амьтан ургамлыг нээлээ. Сарьсан багваахай мэт далавчтай аварга сармагчинг харлаа гэж мэдээлсэн нь "4 сарын 1" байв.

Хэдэн жилийн өмнө "Залуучууд" сонины нэгэн дугаарт "Монголд анх удаа алмас барилаа" гэсэн өгүүлэлг нийтлэгдэж нийгмээрээ нэг шуугисан ч эцэст нь "4 сарын 1" болохыг мэдэцгээсэн. Мөн Тэнэгүүдийн баяр, Маанагуудын өдөр гэх нь ч бий. Хуурдаг өдөр гэдгийг мэдсээр байж хууртаад байдаг болохоор тэгж нэрлэсэн ч байж болох.



Манай улсад 1968 оноос эхлэн Монголын зохиолчдын хороо дөрөвдүгээр сарын 1-нийг Инээдмийн өдөр болгон жил бүр тэмдэглэж байхаар тогтжээ. Эл өдөртэй холбоотой зохиогддог уламжлалт уралдаан тэмцээн, наадам ч манайд цөөнгүй. "Азтай бадарчин", шог зургийн уралдаан, хошин дууны тэмцээн гэх мэт. Харин сүүлийн жилүүдэд хошин урлагийнхан шоу тоглолт тавьдаг болсон. Ташрамд сонирхуулахад, улсын хэмжээнд инээдмийн өдөрт зориулсан хошин урлагийн уламжлалт тоглолт 24 жилийн түүхэнд 46 мянган удаа тайзнаа тоглогдож, 26 сая хүнд инээд бэлэглэж, 256 удаа хандивын тоглолт хийсэн гэдэг статистик бий.